



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 8/78

Улаанбаатар хот

Гадаад сургалтад хамруулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 5.37, 5.41, 5.42, 5.43 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO), Бүгд Найрамдах Солонгос Улсын Газар, дэд бүтэц, тээврийн яам (MOLIT)-тай хамтран Бүгд Найрамдах Солонгос Улсын Нисэх буудлуудын корпорацид зохион байгуулагдах “Удирдах ажилтнуудад зориулсан нисэхийн бодлого” сэдэвт тэтгэлэгт сургалтад Иргэний нисэхийн үндэсний төвийн Агаарын навигацийн үйлчилгээний газрын дарга Э.Төрбаяр болон Нисэхийн сургалтын төвийн захирал Б.Урантөгс нарыг 2022 оны 4 дүгээр сарын 24-ний өдрөөс 5 дугаар сарын 01-ний өдрүүдэд хамруулсугай.

2. Гадаад сургалтад хамрагдсан тухай тайлан гаргаж ажлын 3 хоногийн дотор удирдлагад тайлагнахыг Э.Төрбаяр, Б.Урантөгс нарт, ажил үүрэгт нь зохицуулалт хийж, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын газар (Г.Батбаяр), Захиргаа удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН